

ЭРДЭНЭ РЕСУРС 2024 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ТАЙЛАН БА БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот

2025.11.14

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь 2024 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Монголиан Майнинг Корпорэйшн ("MMC")-тэй хамтран хөгжүүлж буй Баянхөндий алтны төсөл ("БХ" эсвэл "Төсөл")-ийн тухай мэдээллийг хүргэж байна. SEDAR болон компанийн вебсайт дээр байршуулсан 2024 оны 3-р улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" эсвэл "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй хэсэг болно.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "2024 оны гуравдугаар улиралд бид Монгол Улсын баруун өмнөд хэсэгт орших Баянхөндий алтны төслийн хөгжүүлэлтэд ихээхэн ахиц дэвшил гаргаж, төлөвлөсөн уурхайн зэрэгцээ тэлэх боломж бүхий хайгуулын үр дүнгүүдийг танилцуулсан амжилттай байлаа."

"9-р сарын эцэст Баянхөндий алтны төслийн үндсэн байгууламж болох боловсруулах үйлдвэр 55%-ийн гүйцэтгэлтэй байна. Түүнчлэн, үндсэн тоног төхөөрөмжүүд төслийн талбайд тээвэрлэгдэн ирж, бөмбөлөгт болон хагас өөрөө нунтаглах тээрмийн суурилуулалтыг гүйцэтгэж дууссан. Хаягдлын нэгдсэн байгууламж, 400 ажилтны кэмпийн цогцолбор, 110кВ цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг үйлдвэрийн бус дэд бүтцийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажлууд үргэлжилж, төслийн ерөнхий гүйцэтгэл 45%-д хүрээд байна.

Тэрээр үргэлжлүүлэн, "Боловсруулах үйлдвэр болон үйлдвэрийн бус бусад үндсэн байгууламжийг ирэх саруудад хааж, 2025 оны 1-р улирал хүртэл механик болон цахилгааны ажлуудыг дуусган, 2025 оны 2-р улиралд улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. Бид 2025 оны дундуур эхний алтыг үйлдвэрлэн, 3-р улиралд алтны олборлолтыг тогтворжуулах зорилготой ажиллаж байна. Энэ оны 4-р улиралд Эрдэнэ Монгол ХХК-ийн удирдлагууд бүтээн байгуулалтыг дуусгахад зардлын нарийвчилсан тооцооллыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төслийн цар хүрээний өөрчлөлт, тээвэр болон цаг уураас үүдэлтэй саатлуудаас шалтгаалан хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх магадлалтай боловч эдгээр нөлөөллийг боломжит санхүүжилтээр зохицуулах боломжтой гэж үзэж байна."

"3-р улиралд Баянхөндий ил уурхайн зэрэгцээ байршилд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр тухайн бүсэд өнөөг хүртэл илрүүлсэн хамгийн өндөр агуулгууд илэрч, цаашид тэлэх боломжтойг харууллаа. Мөн өнгөрсөн улиралд хүдрийн агуулгын хяналтын өрөмдлөгийг гүйцэтгэсэн ба энэ нь нөөцийн загвартай нийцэн, Баянхөндий ордын газрын дөт гүнд орших бүсэд өндөр агуулгатай алтны хүдэржилтийг баталгаажуулсан. Үр дүнг ирэх саруудад шинэчлэгдэх Баянхөндийн уурхайн төлөвлөгөөнд тусгах болно."


2024 оны 3-р улирлын онцлох үйл явдлууд:







Зураг: Баянхөндий төслийн талбай – 2024 оны 3-р улирал



Баянхөндий Алтны Төсөл

- Баянхөндий төслийн бүтээн байгуулалтын гүйцэтгэл 2024 оны 9-р сарын 30-ны байдлаар 45%-д хүрсэн.
 - 2024 оны 3-р улирлын эцэст төслийн нийт зардалд ойролцоогоор 70 сая ам.долларыг зарцуулсан ба төслийн цар хүрээний өөрчлөлт, тээвэр болон цаг уураас үүдэлтэй саатлуудаас шалтгаалан хөрөнгийн зарцуулалт нэмэгдэх магадлалтай боловч боломжит санхүүжилтийн хүрээнд зохицуулах боломжтой гэж үзэж байна.
 - Үйлдвэр болон үндсэн байгууламжуудын барилгын ажил улирлын эцэст ~55%-тай байна. Бөмбөлөгт болон хагас өөрөө нунтаглах тээрмүүдийн механик тоног төхөөрөмжийн угсралт, томоохон бетон цутгалтын ажлуудыг гүйцэтгэсэн.
 - Үйлдвэрийн бус дэд бүтцийн бүтээн байгуулалт болох кэмп, 110кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, агуулах, засварын цех, захиргааны барилга болон шугам сүлжээний ажил амжилттай урагшилж байна.
 - 2025 оны 1-р улиралд бүтээн байгуулалтын дийлэнх хувийг эцэслэн, 2-р улиралд улсын коммист хүлээлгэн өгснөөр 2025 оны дундуур анхны алтыг үйлдвэрлэн 3-р улиралд олборлолтыг тогтворжуулахаар төлөвлөсөн.
 - Улирлын эцсийн байдлаар төслийн талбайд ойролцоогоор 650 ажилтан ажиллаж, байгаль орчин, хөдөлмөрийн чадвар түр алдалтгүй 2,000,000 орчим хүн/цаг ажилласан амжилттай байна.
- Орон нутаг болон оролцогч талуудын хамтын ажиллагааны ажлын хүрээнд:
 - Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу 2024 онд төлөвлөсөн орон нутгийн хөгжлийн төсөл хөтөлбөрийг дэмжин ажилласан.

- Хүнд машин механизмын операторын сургалтыг 7 дахь удаагаа зохион байгуулж, орон нутгийн нийт 140 иргэдийг хамруулсан ба MMC-ийн Ухаа худаг уурхайд дадлагажин ажиллаж байна.
- Орон нутгийн иргэдийн усны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд гурван худаг суурилуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлж ажилласан.

Хөндий Эрдсийн Дүүргийн хайгуулын хөтөлбөр

- 1500 метр Баянхөндийн хүдрийн хяналтын өрөмдлөгийг гүйцэтгэсэн
 - 1,048 тууш метрийн 89 гүехэн алмазан өрөмдлөгийн цооног бүхий хүдрийн хяналтын өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн. Энэхүү хөтөлбөр нь олборлолтын эхний 3-4 сарын хугацаанд олборлохоор төлөвлөсөн гадаргаас 15 метрийн гүнд орших өндөр агуулгатай бүсүүдэд төвлөрсөн. Мөн ирээдүйн уурхайн төлөвлөлтөд ашиглах 456 тууш метрийн 10 цооног өрөмдсөн.
 - Газрын гадаргаас 12 метрийн турш 6.61 г/т алтны агуулга бүхий интервал огтолсон үр дүнгүүд нь өнөөгийн блок модел дахь өндөр агуулга бүхий бүсүүдийг баталгаажуулж байна.
- Баянхөндийн ил уурхайн нөөцийг тэлэх боломжийг судлахаар 950 метрийн өргөтгөлийн өрөмдлөгийг гүйцэтгэсэн.
 - Бүх цооногууд алтны хүдэржилттэй давхаргыг огтолж, нөөцийг нэмэгдүүлэх болон ил уурхайн хязгаарыг тэлэх боломжтойг харууллаа.
 - Үр дүнгүүдэд Баруун Страйкер бүсэд бүртгэгдсэн хамгийн өндөр агуулгатай огтлол багтсан ба онцлох үр дүнд: VKD-377 цооногт 7.3 г/т алтны агуулга бүхий 42 метрийн интервал огтолсон ба үүнд 15-79 г/т алтны агуулга бүхий хэд хэдэн интервал багтаж байна.

Компанийн тухай

- Компани нь 2024 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$1,687,580 цэвэр алдагдалтай байсан ба 2023 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$1,200,099 цэвэр алдагдалтай байв.
 - 2024 оны 9 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон гурван сарын хугацаанд хайгуул, үнэлгээний зардал \$215,903 байсан нь 2023 оны мөн үеийн \$219,670-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Стратегийн түншлэлийг эцэслэсэнтэй холбоотойгоор Монгол дахь оффисын капиталжуулаагүй зардал өссөн ч ажилтнуудын жилийн гүйцэтгэлийн болон опционы урамшууллын зардал буурснаар дээрх нэмэгдэл нөхөгдсөн.
 - Компанийн ерөнхий ба захиргааны зардал нь 2024 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$582,089 байсан нь 2023 оны мөн үеийн \$600,595 -тай харьцуулахад буурсан үзүүлэлт. Энэ бууралт нь ажилтнуудын жилийн гүйцэтгэлийн урамшуулал, ИОХЭ олголтыг 2023 онд 3-р улиралд олгосон бол 2024 онд 2-р улиралд хийснээс үүдэлтэй бөгөөд энэ нь хөрөнгө оруулагчдын айлчлалтай холбоотой маркетингийн зардал нэмэгдсэнээр хэсэгчлэн нөхөгдсөн.
 - Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүдсэн алдагдал 2024 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$918,649 байсан ба

өнгөрсөн оны мөн үед \$445,493 байв. Энэ нь 2024 оны 2-р сард санхүүжилт хийгдсэнээр Эрдэнэ Монгол ХХК-ийн капиталжуулаагүй хүүгийн зардал нэмэгдсэнтэй холбоотой ба үүнийг 2024 оны эхний улиралд эцэслэсэн Стратегийн түншлэлийн дараах Эрдэнэ Ресурсийн эзэмшлийн хувь өөрчлөгдсөнөөр хэсэгчлэн нөхсөн.

Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба хэвлэлийн мэдээг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувь эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: info@erdene.com

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>